

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А20

Сүмбэр сум

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа  
хүүхдийн хөгжил оролцоог дэмжихэд хөрөнгө  
зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны “Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/10 дугаар тушаал, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 дугаар зүйлийн 5.6, байгууллагын “Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрсдэлийн үнэлгээний программд бүртгэлтэй хүүхдүүдийн хөгжил оролцоог дэмжих ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус үйл ажиллагааг зохион байгуулж, тайлагнахыг сэтгэл зүйч (Г.Мөнхчимэг)-т үүрэг болгосугай.

3. Тус үйл ажиллагаанд шаардагдах 880000 (найман зуун наян мянга) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

2021.03.10.34

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
03 сарын 10-ний өдрийн  
дугаар тушаалын 1-р хавсралт



**ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ БАЙГАА ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ОРЛОЦООГ  
ДЭМЖИХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Говьсүмбэр аймаг

2021.03.10

**Үндэслэл:** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд 2020 оны 10 дугаар сараас эхлэн 11 сар хүртэлх хугацаанд эрсдэлтэй байж болзошгүй нийт 1216 айл өрхүүдээр айлчлан хүүхдүүдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийн, эрсдэл дунд болон өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг эрсдэлийн үнэлгээний программд нэмж оруулан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Эдгээр айл өрхүүдээр айлчлан явахад ажиглагдсан нийтлэг зүйл нь хүүхдүүдэд теле хичээлээ хийх зурагт, гар утас, интернет хэрэглээ байхгүй, сурч хөгжих орчин нөхцөл, боломж бололцоо дутмаг, хүүхдүүдэд унших ном, сурах бичиг, хичээлийн хэрэгслээр хомс, чөлөөт цагаа зөв, үр дүнтэй өнгөрөөх, сонирголоо хөгжүүлэх, гэр бүлийн орчинд хөгжих боломжгүй байгаа зэргээр хүүхдийн хөгжих эрх энд зөрчигдөж байсан юм. Тиймээс эдгээр хүүхдүүдэд сурч боловсорч, хөгжиж дэвшихэд нь зайлшгүй дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарч байна.

**Хамрах хүрээ:** Эрсдэлийн үнэлгээний программд бүртгэлтэй 236 хүүхэд, үүнээс 1-7 насны 67 хүүхэд, 8-13 насны 103 хүүхэд, 14-18 насны 65 хүүхэд байна. Насны ангиллаар нь хүүхдийн тоог харуулбал:

1 нас	2 нас	3 нас	4 нас	5 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас	15 нас	16 нас	17 нас	18 нас
3	7	7	10	7	19	14	17	20	13	21	12	20	14	16	7	26	2

**Зохион байгуулагч:** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗОУБ Бор-Өндөр ОНХ-1

**Хугацаа:** 2021 оны 03 дугаар сарын 11-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

**Ажлын төлөвлөгөө:**


№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
---	---------------------------	---------	---------------

1	Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном зохиол сонгон худалдан авах,	3 сар	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
2	Хүүхдийн гэрээр айлчлан 2 дахь шатны эрсдэлийн үнэлгээ хийх, ном зохиол болон номын тэмдэглэл тараах,	3 сар	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг Хүүхдийн эрх, хамгаалал ХЭУБ Б.Шархүү
3	14-18 настай хүүхдүүдэд цахим сургалт зохион байгуулах,	4 сар	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг Залуучуудын хөгжил оролцоо хариуцсан ажилтан Б.Урангоо Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг
4	Хамгийн сайн номын тэмдэглэл хөтөлсөн хүүхдүүдийг шагнаж урамшуулах.	4 сар	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг

**Үр дүн:** Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд сурч боловсрох, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх боломжийг бүрдүүлж, оюун ухаан, сэтгэхүйн хувьд хөгжиж, чөлөөтэй бодож сэтгэх, унших бичих чадвараа сайжруулах, гэр бүлийн орчинд өөрийгөө хөгжүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог дэмжиж ажилласан байна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН  
СЭТГЭЛ ЗҮЙЧ:  Г.МӨНХЧИМЭГ

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
03 сарын 10 -ний өдрийн А/20  
дугаар тушаалын 2-р хавсралт




ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ БАЙГАА ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦООГ  
ДЭМЖИХ АЖЛЫН ТӨСӨВ


Говьсүмбэр аймаг

2021.03.10

№	Номны нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
ДЗОУБ-аас гарах төсвийн задаргаа				
1.	Анне франкийн өдрийн тэмдэглэл	10 ш	18.000	180.000
2.	Ухаан далай номноос эхтэй	50ш	10.000	500.000
3.	Сургамжит өгүүллэгүүд	50 ш	12.500	125.000
4.	Танин мэдэхүйн аялал /Эх дэлхийн/	10 ш	16.000	160.000
5.	Танин мэдэхүйн аялал /Сансар огторгуй/	10 ш	16.000	160.000
6.	Миний дотор хэн байна вэ?	10 ш	13.000	130.000
7.	Бичгийн цаас	10 боодол	11.000	110.000
8.	Сургалтын дэвтэр	65 ш	2450	159.250
9.	Тосон бал	65 ш	490	33.320
10.	Тодруулагч	65 ш	588	38.220
11.	Мобикомын нэгж	20 ш	2000	40.000
12.	Скайтелын нэгж	10 ш	2000	20.000
13.	Жи мобайлын нэгж	10 ш	2000	20.000
14.	Юнителын нэгж	25 ш	2000	50.000
15.	Баримлын шавар 10 өнгийн	5 ш	4000	20.000
16.	Зургийн дэвтэр	5 ш	3000	15.000
17.	Өнгийн цаас А4	5 ш	4900	24.500
18.	Хайч	5 ш	1470	7.350
19.	Цаасны цавуу	5ш	1960	9.800
20.	Паламастер	5 ш	5880	29.400
21.	Хэлбэртэй стикер	5 ш	980	4.900
22.	Баллуур	5 ш	394	1.970
23.	Үзүүрлэгч	5ш	1960	9.800
<b>Нийт</b>				<b>1.848.510</b>
ГБХЗХГ-аас гарах төсөв				
1.	Дэлхийн хүүхдийн сонгодог уран зохиолын ном	65 ш	12000	780.000
2.	Сэтгэл зүйн үйлчилгээ нэн шаардлагатай хүүхдүүдэд зориулсан сэтгэл заслын "Мандала" ном	5 ш	20000	100.000
<b>Нийт</b>				<b>880.000</b>

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН  
СЭТГЭЛ ЗҮЙЧ:  Г.МӨНХЧИМЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**“ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ  
БАЙГАА ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ,  
ОРОЛЦООГ ДЭМЖИХ”  
ТӨСӨЛ**

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН  
СЭТГЭЛ ЗҮЙЧ: Г.МӨНХЧИМЭГ

## 1. Төслийн танилцуулга

- 1.1 Төслийн нэр: Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн хөгжил оролцоог дэмжих
- 1.2 Төслийн байршил: Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- 1.3 Хугацаа: 2021.01.07-2021.02.07
- 1.4 Төслийн хэрэгжүүлэгч: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
- 1.5 Санхүүжүүлэгч байгууллага: “Дэлхийн Зөн Монгол ОУБ”-ын Бор-Өндөр1 ОНХ
- 1.6 Нийт зардал: 1.848.510

## 2. Төслийг гүйцэтгэх үндэслэл:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-т заасны дагуу “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, сурч хөгжих хэвийн орчин алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд 2020 оны 10 дугаар сараас эхлэн 11 сар хүртэлх хугацаанд эрсдэлтэй байж болзошгүй нийт 1216 айл өрхүүдээр айлчлан хүүхдүүдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийн, эрсдэл дунд болон өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг эрсдэлийн үнэлгээний программд нэмж оруулан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Эдгээр айл өрхүүдээр айлчлан явахад ажиглагдсан нийтлэг зүйл нь хүүхдүүдэд теле хичээлээ хийх зурагт, гар утас, интернет хэрэглээ байхгүй, сурч хөгжих орчин нөхцөл, боломж бололцоо дутмаг, хүүхдүүдэд унших ном, сурах бичиг, хичээлийн хэрэгслээр хомс, чөлөөт цагаа зөв, үр дүнтэй өнгөрөөх, сонирхолоо хөгжүүлэх, гэр бүлийн орчинд хөгжих боломжгүй байгаа зэргээр хүүхдийн хөгжих эрх энд зөрчигдөж байсан юм. Тиймээс эдгээр хүүхдүүдэд сурч боловсорч, хөгжиж дэвшихэд нь зайлшгүй дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарч байна.

### 2.1 Төслийн зорилго:

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд өөрийн оюун ухаан, авьяас билэг, ур чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хүүхэд чөлөөтэй сэтгэж бодох, бичиг үсэг, тооны ухаанд

суралцах зэргээр хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх, хөгжих боломж бололцоог бүрдүүлэхэд төслийн зорилго оршино.

2.2 **Төслийн хамрах хүрээ:** Эрсдэлийн түвшин тогтоох программд бүртгэлтэй 236 хүүхэд, үүнээс 1-7 насны 67 хүүхэд, 8-13 насны 103 хүүхэд, 14-18 насны 65 хүүхэд байна. Насны ангиллаар нь хүүхдийн тоог харуулбал:

1 нас	2 нас	3 нас	4 нас	5 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	11 нас	12 нас	13 нас	14 нас	15 нас	16 нас	17 нас	18 нас
3	7	7	10	7	19	14	17	20	13	21	12	20	14	16	7	26	2

2.3 **Төсөлд шаардагдах зүйлс:** Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном сурах бичиг. Үүнд: дэлхийн сонгодог уран зохиолын ном, танин мэдэхүйн ном, сургамжит өгүүллэгүүд, сургалтад ашиглах бичиг хэргийн материал, утасны нэгж, шагналын бэлэг.

### 3. Хүрэх үр дүн

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд сурч боловсрох, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх боломжийг бүрдүүлж, оюун ухаан сэтгэхүйн хувьд хөгжиж, чөлөөтэй бодож сэтгэх, унших бичих чадвараа сайжруулах, гэр бүлийн орчинд өөрийгөө хөгжүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлсэн байна.

### 4. Төслийн ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төсөл бичих	1 сар	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
2	Төслийн санхүүжилтээ хүлээн авах	1 сард	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
3	Төсөл хэрэгжих	1-2 сард	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
4	14-18 настай хүүхдүүдэд онлайн сургалт зохион байгуулах	1-2 сард	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг Залуучуудын хөгжил оролцоо хариуцсан ажилтан Б.Урангоо Хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг
5	Хамгийн сайн номын тэмдэглэл хөтөлсөн хүүхдүүдэд шагнал гардуулах	02 сард	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг

5. Төсвийн зарцуулах задаргаа

№	Номны нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Анне франкийн өдрийн тэмдэглэл	10 ш	18.000	180.000
2.	Ухаан далай номноос эхтэй	50ш	10.000	500.000
3.	Сургамжит өгүүллэгүүд	50 ш	12.500	125.000
4.	Танин мэдэхүйн аялал /Эх дэлхийн/	10 ш	16.000	160.000
5.	Танин мэдэхүйн аялал /Сансар огторгуй/	10 ш	16.000	160.000
6.	Миний дотор хэн байна вэ?	10 ш	13.000	130.000
7.	Бичгийн цаас	10 боодол	11.000	110.000
Нийт				1.365.000
<b>Сургалтад ашиглах бараа материал</b>				
1.	Сургалтын дэвтэр	65 ш	2450	159.250
2.	Тосон бал	65 ш	490	33.320
3.	Тодруулагч	65 ш	588	38.220
4.	Мобикомын нэгж	20 ш	2000	40.000
5.	Скайтелын нэгж	10 ш	2000	20.000
6.	Жи мобайлын нэгж	10 ш	2000	20.000
7.	Юнителын нэгж	25 ш	2000	50.000
Нийт				360.790
<b>Шагналын бараа материал</b>				
1.	Баримлын шавар 10 өнгийн	5 ш	4000	20.000
2.	Зургийн дэвтэр	5 ш	3000	15.000
3.	Өнгийн цаас А4	5 ш	4900	24.500
4.	Хайч	5 ш	1470	7.350
5.	Цаасны цавуу	5ш	1960	9.800
6.	Паламастер	5 ш	5880	29.400
7.	Хэлбэртэй стикер	5 ш	980	4.900
8.	Баллуур	5 ш	394	1.970
9.	Үзүүрлэгч	5ш	1960	9.800
Нийт				122.720

Нийт төсөв: 1.848.510

6. ХАВСРАЛТ

